

| Д/д | Оролцогчийн тодруулга | Захиалагчийн хариулт |
|-----|--|--|
| 1 | <p>Тус тендерийн гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцлүүдэд тусгах чухал нөхцлүүдийг захиалагчийн зүгээс тодруулж өгөхгүйгээр "ТШББ-ийн ТШЗ 38.2-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно" гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ үү." гэсэн хариу өгсөөр байгаа нь мөн "хэлэлцээрийн шатанд шийднэ" гэх нь та бүхний "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.6.2-т заасныг оролцогч дагаж мөрдөнө." гэсэн тодруулгатай хууль зүйн хувьд зөрчилдөж байгааг анхаарна уу. Хэлэлцээр гэдэг бол гэрээ байгуулахын өмнөх шат буюу байгуулахаас татгалзсан тохиолдолд аливаа тал хариуцлага хүлээхгүй байх зарчимтай. Холбогдох хуулийн Шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө Монгол Улсын Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай 2005 оны хуулийн 36.16-д "36.16.Захиалагч энэ хуулийн 37-39 дүгээр зүйлийн дагуу техникийн болон санхүүгийн саналыг үнэлж, сонгосон зөвлөхтэй хийсэн хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд түүнд энэ хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу гэрээ байгуулах эрх олгоно." гэж зааснаар зохицуулдаг байсан. Шинэчилсэн найруулгад ийм заалт байхгүй байгаа нь асуудал дагуулж биднийг хэлэлцээрийн шат амжилтгүй болвол тендерийн баталгаагаа алдах бодит эрсдэл үүсгэж байна. Иймд та бүхэн энэ бодитой асуудлыг харгалзан үзэж тус тендер шалгаруулалтын хүлээн авах эцсийн хугацааг сунгаж цааашлаад дахин уулзалт зохион байгуулж эсхүл тодруулга оруулах хэлбэрээр гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлүүдэд нэмэлт өөрчлөлт оруулж тодорхой болгох арга шийдэл байна гэж бид үзэж байна.</p> | <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 39 дүгээр хуулийн 39.1 дэх хэсэг Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна. Мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийг үндэслэн Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна.</p> |
| 2 | <p>Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын хамт олон танаа, Тус тендерийн гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцлүүдэд тусгах чухал нөхцлүүдийг захиалагчийн зүгээс тодруулж өгөхгүйгээр "ТШББ-ийн ТШЗ 38.2-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно" гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ үү." гэсэн хариу өгсөөр байгаа нь мөн "хэлэлцээрийн шатанд шийднэ" гэх нь та бүхний "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.6.2-т заасныг оролцогч дагаж мөрдөнө." гэсэн тодруулгатай хууль зүйн хувьд зөрчилдөж байгааг анхаарна уу. Хэлэлцээр гэдэг бол гэрээ байгуулахын өмнөх шат буюу</p> | <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 39 дүгээр хуулийн 39.1 дэх хэсэг Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна. Мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийг үндэслэн Худалдан авах гэрээний үүргийн</p> |

| | | |
|---|---|---|
| | <p>байгуулахаас татгалзсан тохиолдолд аливаа тал хариуцлага хүлээхгүй байх зарчимтай. Холбогдох хуулийн Шинэчилсэн найруулга батлагдсахаас өмнө Монгол Улсын Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчлгээ авах тухай 2005 оны хуулийн 36.16-д "36.16.Захиалагч энэ хуулийн 37-39 дүгээр зүйлийн дагуу техникийн болон санхүүгийн саналыг үнэлж, сонгосон зөвлөхтэй хийсэн хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд түүнд энэ хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу гэрээ байгуулах эрх олгоно." гэж зааснаар зохицуулдаг байсан. Шинэчилсэн найруулгад ийм заалт байхгүй байгаа нь асуудал дагуулж биднийг хэлэлцээрийн шат амжилтгүй болвол тендерийн баталгаага алдах бодит эрсдэл үүсгэж байна. Иймд та бүхэн энэ бодитой асуудлыг харгалзан үзэж тус тендер шалгаруулалтын хүлээн авах эцсийн хугацааг сунгаж цаашлаад дахин уулзалт зохион байгуулж эсхүл тодруулга оруулах хэлбэрээр гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлүүдэд нэмэлт өөрчлөлт оруулж тодорхой болгох арга шийдэл байна гэж бид үзэж байна. Хэрэв энэ асуудал шийдэгдэхгүй бол дэлхийд хүндтэй бусад метроны зөвлөх компаниуд тус тендер оролцохоос татгалахаас өөр аргагүй болоод байна. Та бүхэн бидний тавьсан асуудлыг бидний гаргасан саналын хамт шуурхайгаар нухацтай хэлэлцэж аль аль талыг хохироохооргүй шийдлийг олж өгнө үү.</p> | <p>гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна.</p> |
| 3 | <p>Бид Бьюроу Веритас Инспекшэнь Тестин Монголиа ХХК нь тендерийн бичиг баримтад заасан техникийн болон чадавхын шаардлагыг хангасан олон улсын компанийн (Бьюроу Веритас Групп) Монгол дах охин компани юм. Олон улсын компанийн охин компани нь хамаарал бүхий гадаадын компанийн техникийн болон чадавхын туршлагыг нотолсон бичиг баримтыг хавсаргаж, тендер саналаа явуулж болох уу? Хэрвээ болохгүй бол хууль тогтоомжийн дагуу хязгаарласан зохицуулалт байгаа юу? Захиалагч талаас тендер ялсан гадаадын компанийг охин компани Монгол элсэд бүртгүүлэхийг шаардах уу?</p> | <p>Танай компани тус олон улсын шаардлага хангасан “Бьюроу Веритас Групп”-ын тодорхой нэг чиглэлийг хариуцсан бие даасан хуулийн этгээд (аж ахуйн нэгж) тул боломжгүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар хуулийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээдийн тендерийг хүлээн авна.</p> |
| 4 | <p>Тендер шалгарсны дараа шалгарсан тендер хамт ирүүлсэн гэрээний урьдчилсан нөхцлүүдийг захиалагчийн зүгээс хүлээн зөвшөөрөөгүй улмаас гэрээ байгуулахгүй болох тохиолдолд тендерийн баталгааг оролцогчид буцаан олгох уу?</p> | <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай гэрээний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг</p> |

| | | |
|---|--|--|
| | | <p>болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна.</p> <p>Мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийг үндэслэн Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна.</p> <p>Харин Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.6.2 дах заалтад заасан нөхцөл хангагдаж байгаа тохиолдолд буцаан олгох боломжгүй.</p> |
| 5 | <p>ТШЗ19.1.3 ижил төстэй төслүүдэд 3-аас доошгүй удаа газрын доор, газрын дээр, зураг төсөл болон барилгын хяналтаар төслийн зөвлөхийн үндсэн гүйцэтгэгчээр тооцно гэсэн байна. Үүнд дараах 4 ажлуудыг хамтад нь тус бүр хийсэн нийлээд 3 төсөл, арга хэмжээ гэж ойлгох уу. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь дээрх ажлуудаас салангид хийсэн байж болох уу. Үүнд: 1. Газар дээрх</p> <p>2. Газар доорх</p> <p>3. Зураг төсөл</p> <p>4. Барилгын хяналт</p> | <p>Оролцогч ТШББ-ийн ТШЗ 19.1.3-т заасны дагуу ижил төстэй үйлчилгээ үзүүлж байсан туршлагыг нотлохоор ирүүлсэн үйлчилгээг тус тусад нь хийсэн байж болно. Захиалагчаас шаардсан 4 төрлийн туршлагыг нотлох төсөл, арга хэмжээ нь заавал 1 төсөл, арга хэмжээгээр хангагдах шаардлагагүй.</p> |